



**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар A/78

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, Компанийн дүрмийн 9.9.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амгалан дулааны станц ТӨХК-ийн “Спорт заал ашиглалтын журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Шинэчлэн батлагдсан журмыг 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагч Ш.Отгонбаярмаад үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хуулийн мэргэжилтэн (Г.Саруул)-д тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.БАЯНМӨНХ

Амгалан дулааны станц ТӨХК-ийн  
Гүйцэтгэх захирлын 2022 оны... дугаар сарын  
...-ны өдрийн ... дугаар тушаалын хавсралт



## СПОРТ ЗААЛ АШИГЛАЛТЫН ЖУРАМ

### 1. Зорилго

Компанийн спорт заалтай холбогдох харилцааг зохицуулах, заал, эд хогшил ашиглагч нарын дэг журмыг хангахад энэхүү журмын зорилго оршино.

### 2. Журмыг дагаж мөрдөх хүрээ

- 2.1 Спорт заалаар үйлчлүүлж байгаа Амгалан дулааны станц ТӨХК-ийн ажилтнууд  
2.2 Түрээсийн гэрээгээр заал эзэмшиж байгаа хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагууд

### 3. Төлбөр тооцоо

3.1 Амгалан дулааны станц ТӨХК-ийн ажилтнуудын чөлөөт тоглолт, тэмцээн уралдаан үнэ төлбөргүй зохион байгуулагдана.

3.2 Спорт заал ашиглалтын төлбөр 1 цагийн 70,000 /Далан мянга/-н төгрөг байна.

3.3 Компанийн нэгжүүдийн тоглолтын хуваарьт өдрөөс бусад өдөр, цагуудад гадны иргэдэд Спорт заал ашиглуулах зөвшөөрлийг Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ. Гүйцэтгэх захирал зөвшөөрсөн тохиолдолд төлбөрийг заал ашиглах өдрөөс 1-3 хоногийн өмнө компанийн харилцах дансанд шилжүүлнэ.

3.4 Түрээслэгч нь “Спорт заал түрээслэх гэрээ”, түрээсийн төлбөр төлсөн баримтын нэг хувийг цаасан хэлбэрээр Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагчид хүлээлгэн өгнө.

3.5 Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхгүй.

3.6 Үйлчлүүлэгчид /компанийн ажилтнууд, гэрээ байгуулсан гадны үйлчлүүлэгчид/ спорт заалны эд хөрөнгө, техник хэрэгслийг эвдэж, компанид хохирол учруулсан бол тухайн эд хөрөнгийн марк, хэлбэр загвар, чанарыг алдагдуулахгүйгээр, зах зээлийн үнээр, үл маргалдах зарчмаар 100 хувь төлж барагдуулна.

3.7 Компанийн ажилтнуудыг спортын ямар нэг төрөлд дасгалжуулсан ажлын хөлсөнд тухайн дасгалжуулагчийн шавь нарыг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр үнэ төлбөргүй тоглуулж болно.

3.8 Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагч нь түрээсийн төлбөрийн тооцоог сар бүрийн эцэст Санхүү эдийн засгийн хэлтэстэй хийнэ.

### 4. Талуудын хүлээх үүрэг, хариуцлага

#### 4.1. Компанийн нэгж, ажилтнууд:

4.1.1. Компанийн ажилтнууд батлагдсан хуваарийн дагуу спорт заалаар үйлчлүүлнэ.

4.1.2. Нэгж хариуцсан ахлах ажилтан нь заалны эд хогшил, бөмбөг, тоглолтын бусад хэрэгслийг хүлээн авна.

4.1.3. Ажилтнууд тоглож дууссаны дараа хогоо түүж, зааланд чийгтэй цэвэрлэгээ хийнэ.

#### **4.2. Түрээслэгч нар:**

4.2.1. Түрээслэгч нь спорт заалаар үйлчлүүлэх хүний тоо, нэрсийг үнэн зөв бичиж зөвшөөрлийн бичигт хавсаргасан байна.

4.2.2. Түрээслэгч нь гэрээ, зөвшөөрлийн хуудсанд бичигдсэн цаг, хугацаандаа үйлчлүүлнэ.

4.2.3. Зөвшөөрлийн хуудасны хавсралтад нэр нь бичигдсэн хүний хувийн баримт бичгийг шалгуулж нэвтрүүлнэ.

4.2.4. Түрээслэгч нар өөрийн бөмбөгөөр тоглоно.

#### **4.3. Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагч:**

4.3.1. Спорт заалны эд хөрөнгө, техник хэрэгслэлийн бүрэн бүтэн байдал, ашиглалтад хяналт тавина.

4.3.2. Түрээслэгч нарын дэг журамд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулна.

4.3.3. Спорт заал, теннисний өрөө, ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг хариуцах.

4.3.4. Спорт заалаар үйлчлүүлэгч нарт заал, тоног төхөөрөмж бусад эд хөрөнгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах.

4.3.5. Компанийг төлөөлөн дутагдсан, эвдэрсэн эд хөрөнгийг төлүүлж барагдуулах.

4.3.6. Түрээслэгч нартай гэрээ байгуулах, төлбөр төлсөн тохиолдолд заал хүлээлгэн өгөх.

4.3.7. Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагч нь үүссэн зөрчлийг ноцтой гэж үзвэл нотлох баримт бүрдүүлж компанийн захиргаа, хуулийн байгууллагад мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

4.3.8 Түрээслэгч нь гуравдагч этгээдэд давхар түрээслэхгүй.

#### **4.4. Нийтлэг шаардлага:**

4.4.1.“Спорт заал түрээслэх гэрээ” байгуулсан, түрээсийн төлбөрөө бүрэн төлсөн хувь хүн, аж ахуйн нэгжид спорт заалаар үйлчилнэ.

4.4.2. Компанийн ажилтнуудыг спорт заал, бөмбөг, тор, техник хэрэгслээр хангана.

4.4.3.Шаардлагатай бол дээд байгууллага болон компанийн удирдлагын шийдвэрээр спорт заал ашиглах хуваарийг тодорхой хугацаагаар өөрчилнө.

4.4.4.Спортын зориулалтын хувцастай /биеийн тамирын өмд, шорт, кет, пүүз гэх мэт/, хар зураас гаргадаггүй ултай пүүзтэй байна.

4.4.5.Заалаар үйлчлүүлэгчид хувийн ариун цэвэр, эрүүл мэндийн зохих шаардлагыг хангасан байна.

4.4.6. Үйлчлүүлэгчид спортын заалны эд хөрөнгө, техник хэрэгсэлтэй зөв зохистой харьцах ба хохирол учруулсан тохиолдолд хохирлыг үл маргах журмаар 100% төлж барагдуулна.

4.4.7. Спорт заалаар үйлчлүүлэхдээ тоглолтын дүрэм, аюулгүйн дүрмийг чанд баримтлана.

4.4.8. Үйлчлүүлэгч өөрийн биед байгаа үнэт эдлэл, бэлэн мөнгө, бусад эд зүйлсээ өөрөө хариуцах ба алдагдсан, эвдэрч гэмтсэн тохиолдолд компанийн захиргаа, ажил хариуцсан ажилтан хариуцахгүй.

4.4.9. Үйлчлүүлэгч нь ундаа, усны сав зэрэг хог хаягдлыг зориулалтын саванд хаяна.

4.4.10. Зөвшөөрөгдсөн тамхины цэгт тамхи татна.

4.4.11. Ариун цэврийн өрөөгөөр зөв боловсон үйлчлүүлнэ.

4.4.12. Түрээслэгч, иргэд иргэний үнэмлэх, ажлын үнэмлэх, жолооны үнэмлэх зэрэг хүчин төгөлдөр баримтаа шалгуулж харуулын шалган нэвтрүүлэх пост, зааланд нэвтэрнэ.

4.4.13. Компанийн хашаанд автомашинаар 5 км/цагаас илүүгүй хурдтай явах ба спорт заалны урд талын зогсоолд автомашинаа бусдын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр байрлуулна.

4.4.14. Зөвшөөрлийн бичигт нэр нь ороогүй хүнийг нэвтрүүлсэн, дэг журам алдагдуулсан түрээслэгчийн гэрээг цуцалж дахин спорт заалаар үйлчлэхгүй.

4.4.15. Спорт зааланд 22 цагаас хойш чөлөөт тоглолт, уралдаан тэмцээн явуулахгүй.

#### **4.5. Дараах зүйлийг хориглоно.**

4.5.1. Спорт заалаар үйлчлүүлэгч хуваарьт цагийг хэтрүүлэх,

4.5.2. Түрээсийн төлбөр төлсөн баримт, “Спорт заал түрээслэх гэрээ”-г авч ирэхгүйгээр зааланд нэвтрэхийг шаардах,

4.5.3. Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагчийн зөвшөөрөлгүйгээр заалны техник, тоног төхөөрөмж, компанийн эд хөрөнгө ашиглах.

4.5.4. Спорт зааланд тамхи татах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хэрэглэсэн үедээ орох, оруулахыг шаардах,

4.5.5. Спорт зааланд шүлс, нус цэрээ хаях, зөвшөөрөлгүй чанга яригч ашиглах, орилох зэрэг зохисгүй үйлдэл гаргах,

4.5.6. Зөвшөөрөлгүй анонс байрлуулах, плакат наах, сурталчилгаа хийх,

4.5.7. Удирдлагын зөвшөөрөлгүй бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх,

4.5.8. Тэсэрч, дэлбэрэх болон галын аюултай бодис, галын аюулгүй байдал хангаагүй гэрэл, техник хэрэгсэл зааланд оруулах, ашиглах,

4.5.9. Заалны хананд санаатайгаар бөмбөг буюу эд зүйлсээр цохих, нүдэх,

4.5.10. Гадна өмсдөг гутал, пүүз, хар зураас гардаг пүүзтэй тоглолтын талбайд гарах,

4.5.11. Тоглолтын пүүзтэй заалнаас гарах,

4.5.12. Зааланд хэрүүл, маргаан, зодоон хийх,

4.5.13. Компанийн хашаанд сэлгүүцэх, үйлдвэрийн байранд нэвтрэх зэргийг хориглоно.

#### **4.6. Хариуцлага:**

4.6.1. Энэхүү журмыг зөрчсөн ажилтанд сахилгын шийтгэл ногдуулна.